

ПАК ЖӨН ХИ БА ӨМНӨД СОЛОНГОС

Дэд доктор Д.Уламбаяр

Улс үндэстнээ өөд нь татах эрхгүй нэгэн үзүүрт зүтгэж явсан БНСУ-ын улс төр, цэргийн томоохон зүтгэлтнүүдийн нэг нь Гурав, дөрөв дэх БНУ-ын ерөнхийлөгч, генерал Пак Жөн Хи юм. Тухайн үед түүнийг “империализмын гар хөл бологч”, “Америкийн империализмын дуулгавартай зарц”, “Цэргийн дарангуйлагч” мэтээр дүрслэн бичиж байсан хэдий боловч он цаг улиран өнгөрөх тутам түүний өөрийн улсын түүхэнд гүйцэтгэсэн нааштай үүрэг улам бүр тодорсоор буй за.

Тэрбээр 1961 оны 5 сарын цэргийн эргэлтийн дүнд Засгийн эрхэнд гарч улмаар хоёр жилийн дараа 1963 онд болсон сонгуулиар Гурав дахь БНУ-ын ерөнхийлөгч болсон түүхтэй. Пак урьд нь дунд сургуулийн багшаар ажиллаж байгаад хожим нь цэргийн генерал болжээ. Түүнийг ерөнхийлөгчөөр ажиллаж байх хугацаанд Өмнөд солонгосын эдийн засаг гайхамшигтай хурдан хөгжсөн бөгөөд (дундажаар 9,2 хувь) бас ч улс төр, нийгмийн хатуу чанга бодлого явуулсан нэгэн гэж хэллэгддэг билээ. Тэрбээр эцэстэй өөрийн ТТГ-ын удирдагчийн гарт харамсалтайгаар хөнөөгдсөн билээ.

Пак Солонгосын зүүн өмнөд этгээдийн Умард Кесан мужийн Тэгү хотоос гучин мод газар орших Соньсан Гуньд 1917 оны есөн сарын 30-нд төржээ. Пак Тэгүд боловсрол олж багшлах эрх олж аваад 1937-1940 он хүртэл Мункён хэмээх бага сургуульд багшилж байв. Цаашдаа цэргийн салбарт ажиллахаар шийдэж 1940 онд Манж-Го улсын Цэргийн Академид элсэн орж хоёр жил суралцжээ. Академиа онц дүнтэй төгссөн нь түүнийг Японы Эзэн Хааны Цэргийн Академид үргэлжлүүлэн суралцах үүдийг нээж өгсөн байна. Пак Дэлхийн II дайны төгсгөлөөр Японы армид I зэргийн дэслэгчийн зиндаанд хүрсэн байв. Дайны дараа Солонгосын Цэргийн Академид элсэн орж цэргийн бүрэн курст суралцаж 1946 онд ахмад болжээ. 1948 онд тэрбээр олонхи солонгосчуудын адил Солонгосын хойг хоёр хуваагдсанд зэвүүцэн дургүйцэж байлаа. Тэгэхэд Пакт үхлийн ял оногдсон боловч удалгүй өршөөгдөж цэргийн хэргэм зэргээ сэргээлгэж чаджээ. Солонгосын дайны төгсгөл үе 1953 онд гэхэд Бригадын генерал болтлоо дэвшсэн байв. Удалгүй АНУ-ын Оклахома мужийн Форт Стилл дэх Америкийн армийн Артиллерийн сургуульд мэргэжил дээшлүүлжээ.

* МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн багш

Тэрбээр солонгостоо буцаж ирээд 1958 онд хошууч генерал болохоосоо өмнө хэд хэдэн чухал албанд томилогдон ажиллаж байв.

Тэрчлэн 50-иад оны сүүл, 60-аад оны эхээр улс оронд улс төр, эдийн засгийн ноцтой хурц асуудлууд хуримтлагдан ужигарч байлаа. 1960 оны ерөнхийлөгчийн сонгуулийн компанит ажил будлиантай явагдаж, үүнийг эсэргүүцсэн оюутны жагсаал цуглаан ихэсч, олон түмний дургүйцэл ширүүсч эцэст 3 сарын 15-ны үр дүнг эсэргүүцсэн бүх нийтийн жагсаал цуглаан 4 сарын 19-нд оюутны бослого болон өрнөж улс оронд үндсэндээ эмх замбараагүй байдал бий болсон юм. Умардынхан ч үүнийг зүгээр харж суусангүй, зүйл бүрээр өдөөн турхирч дайран дээр давс нэмж байв.

Ийм түүхэн нөхцөлд 1961 оны 5-р сарын 16-ны үүрээр хошууч генерал Пак Жөн Хигээр толгойлуулсан цэргийнхэн эргэлт хийж Хоёр дахь БНУ-ын Засгийн газрыг засаг, төрийн эрхнээс зайлуулжээ. Мөн өдрийн өглөө ард түмэнд радиогоор засгийн бүх эрх Хувьсгалт Цэргийн Зөвлөлд шилжсэнийг мэдэгдэж зургаан зүйлт зорилт тухайлбал коммунизмын эсрэг шийдвэртэй зогсох, хоёрт, НҮБ-ын дүрмийг дээдлэн хүндэтгэх, гуравт, АНУ болон бусад чөлөөт ертөнцийн орнуудтай улам ойртон түншлэх, дөрөвт, хээл хахуулын уг үндсийг таслан зогсоох, тавт, өөрийгөө тэтгэн авч явах эдийн засгийн үндсийг байгуулах, зургаад, солонгос үндэстнийг нэгтгэхийн төлөө хүчин чармайхаа зарлан тунхаглажээ. Түүнчлэн нэн даруй иргэний засгийн газрыг эмхлэн байгуулахаа амлажээ. Удалгүй Хувьсгалт Цэргийн Зөвлөлийг Үндэсний Шинэчлэн Байгуулалтын Дээд Зөвлөл болгон өөрчлөн байгуулжээ. Пак богино хугацаанд тухайлбал 1961 оны 8 сард дэслэгч генерал, 11-р сард армийн генерал болжээ. 1963 оны 8-р сард цэргээс ерөнхийлөгчийн албанд шилжих болж, улмаар өөрийн эмхлэн байгуулсан Ардчилсан Бүгд Найрамдах намаас ерөнхийлөгчид сонгогдон мөн оны 12-р сарын 17-нд уг тушаалд албан ёсоор оржээ.

Энэ үед Японтой харилцаагаа сайжруулах нь нэн чухал байв. Идэвхтэй дипломат үйл ажиллагаа явуулсны дүнд 1965 оны 6-р сард Өмнөд Солонгос, Япон “хоёр улсын хоорондын харилцааг хэвийн болгох тухай гэрээ”-г байгуулж үүгээр Япон улс Сөүлийн Засгийн газрыг “Солонгосын хойг дахь хууль ёсны цорын ганц Засгийн газар” гэж зөвшөөрөн хүлээсэн ба Өмнөд Солонгос ч аанай л Японы үйлдвэр, худалдааны бүлгийнхэнд өөрийн зах зээлийнхээ үүд, хаалгыг нээж өгчээ.

1965 оны 10 сард Падын Засгийн газар АНУ-ын холбоотныхувиар Вьетнамын дайнд (1965-1973 оны хооронд) оролцож Өмнөд Солонгосын нийт 50 мянга орчим цэргийг илгээжээ. Энэ дайнд нийтдээ Өмнөд Солонгосын 3 мянган цэрэг эрс амь насаа алджээ. Хэрэв энэ дайнд Өмнөд

Солонгос цэргээ илгээгээгүй бол АНУ-ын санхүү, эдийн засаг, цэргийн тусламж эрс хорогдох учир шалтгаан ч байлаа.

Пак 1967 оны 5 сард Хоёр дахь БНУ-ын ерөнхийлөгч агсан Юнь Поньтай өрсөлдөн ялж БНСУ-ын ерөнхийлөгчөөр дахин сонгогджээ. Энэ үед Хойт Солонгос Өмнөдийн эсрэг янз бүрийн өдөөн хатгалга хийж байсан цаг юм. 1968 онд гуч орчим цэргийн нэгтгэлүүд цэрэггүй бүсийг нэвтэрч зорилго нь Сөүлд довтолж улмаар Пакуыг хөнөөх төлөвлөгөөтэй байжээ. Өмнөдийн олон солонгосчууд энэ тулаанд амь насаа алдаж харин Умардын цэргийн нэг нэгтгэлийн гишүүн олзлогдож өөрсдийн үйл ажиллагааны зорилгыг бүрэн илчилж, өөр нэг удирдагч нь нэг сарын дараа олон улсын дундын ус Уаньсаны ойролцоох АНУ-ын индианчуудын сууринд олзлогджээ.

1971 оны 4 сард ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчнээс дэвшигдсэн Ким Дэ Жунтэй өрсөлдөн ялжээ.

Түүний гадаад бодлого, дипломатын зоримог үйл ажиллагаа нь 40-өөдхөн улсаар хүлээн зөвшөөрөгдөөд байсан Өмнөд Солонгосыг дэлхийн тавцанд гаргаж 1979 он гэхэд 110 оронтой дипломат харилцаа тогтоож чаджээ. (1960 онд Сөүлд гадаадын арваадхан ЭСЯ байсан бол 1980 онд 80 гаруй ЭСЯ болсон байв). Пакуыг засгийн эрх барьж байх хугацаанд Өмнөд Солонгос нь олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага тухайлбал 1961 онд Олон Улсын Хөгжлийн Агентлаг, 1964 онд Олон Улсын Санхүүгийн Корпараци, 1966 онд Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ын Хууль, Хөгжлийн Бага Хурал, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, 1967 онд ГАТТ-д элсчээ (бүр 1955 онд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банкинд элссэн юм).

Ерөнхийлөгч Пак Жон Хигийн улс төрийн тавцанд нөлөөгөө өргөжүүлэх гэсэн хүчин чармайлт нь эдийн засгийн салбарт олсон амжилтаас үл хамааран нэлээд ширүүн эсэргүүцэлтэй тулгарч байлаа. Гэвч нийгэм-эдийн засагт гарч байсан мэдэгдэхүйц өөрчлөлт, 1972 оны 2 сард АНУ-ын ерөнхийлөгч Р.Никсоны Бээжинд хийсэн айлчлал, ерөнхийлөгч Пакуын санаачлагаар эхэлсэн Өмнөд-Умардын анх удаагийн яриа хэлэлцээр нь төв засгийн газрын нэр хүндийг бэхжүүлсэн юм. Иймээс 1972 оны 10 сард Шинэ Үндсэн Хуулийн институт “Юшин”-ыг хэрэгжүүлж эхэлжээ. “Дахин амилуулах Шинэтгэл” буюу “Юшин” Үндсэн Хууль нь хүчтэй ерөнхийлөгчийн удирдлагын дор улс төрийн тогтвортой байдлыг хангах, нийгэм-эдийн засгийн шинэчлэлийн үйл явцын түүхэн зорилтыг тасралтгүй, иж бүрэн хэрэгжүүлэхэд чиглэгдэж байв. “Юшин” Үндсэн Хуулиар Солонгосын засгийн газрын бүтэц илүү төвлөрсөн шинжтэй болсон байна. Үндсэн Хуулийн өөрчлөлтийн зорилго нь нэгд, олон улсын хүчний хооронд найдвартай, чадварлаг үндэсний батлан хамгаалах чадавхитай байж, нийгэм-эдийн засгийн хөгжлийг амжилтанд

хүргэх, хоёрт, Солонгосыг энх тайвнаар нэгтгэх замыг эрэн хайхад Өмнөд, Умардын яриа хэлэлцээг эхлүүлэх, гуравт, Солонгосын онцлогт нийцсэн ардчлалыг хөгжүүлэх, барууны либерал ардчилсан загварыг боломжит ба хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлэхэд оршиж байв. Шинэ Үндсэн Хуулиар Пак ерөнхийлөгчөөр дахин сонгогдож Дөрөв дэх БНУ-ын үе эхэлсэн билээ.

60-аад оны коммунист Умард Солонгостой ямар нэг яриа хэлэлцээ хийх нь аюултай байсан бөгөөд учир нь эдийн засгийн хөгжил, батлан хамгаалах чадавхи сул дорой байлаа. 70-аад оны үед нөхцөл байдалд сайн тийш өөрчлөгдсөн нь яриа, хэлэлцээг санаачлан эхлүүлэх бололцоог олгож өгөв. 1970 оны 8 сарын 15-ны японы милитаризмаас чөлөөлөгдсний 25 жилийн ойн өдөр ерөнхийлөгч Пак Жон Хи хоёр талын хоорондын харилцаанд оршиж буй зохиомол саад бэрхшээлийг, аажмаар зайлуулж харилцан ойлголцоход бэлэн байгаага илэрхийлсэн тунхаглал дэвшүүлжээ. Гэвч үүнд умардынхан ямарч хариу өгөөгүй юм. 1971 оны 8 сарын 12-нд Солонгосын хойгийн хоёр хэсэгт салж сарнисан ахан дүүс, хамаатан садангуудыг уулзаж учируулах тийш хамтран эрэл хайгуул хийх саналыг Өмнөд Солонгосын Улаан Загалмайн Нийгэмлэгийн ерөнхийлөгч доктор Чой Ту Сон дэвшүүлжээ. Гайхалтай нь Пёняны эрх баригчид энэ саналыг 8 сарын 14-нд хүлээн авсан байна. 1971 оны 9 сарын 30-нд хоёр талын Улаан Загалмайн Нийгэмлэгийн анхны бэлтгэл уулзалт Панмунжомд нээгджээ. 1973 оны 6 сар хүртэл үргэлжилсэн долоон удаагийн уулзалтын хүрээнд 1972 оны 5 сард ерөнхийлөгч Пак өөрийн ТТГ-ын захирал Ю Ху Ракыг Пёнянд нууцаар илгээж тэрбээр дөрөв хоногийн айлчлалын хугацаанд ерөнхийлөгч Ким Ир Сен болон бусад удирдах зүтгэлтнүүдтэй уулзаж Солонгосын хойгт түгшүүртэй байдлыг намжаах, улс орноо энх тайван замаар аажмаар нэгтгэх талаар санал солилцжээ. Удалгүй Ким Ир Сен ч өөрийн төлөөлөгч Пак Сон Чөлийг Сөүлд нууцаар илгээсэн байна. 1972 оны 6 сарын эхээр хоёр тал Солонгос хоорондын дээд түвшинд гарын үсэг зурсан Өмнөд-Умардын хамтарсан мэдэгдлийг Сөүл-Пёнянд нэгэн зэрэг тараажээ. Хамтарсан мэдэгдэлд гадны аливаа хүчний оролцоогүйгээр энх тайвнаар нэгдэх, үзэл суртал, улс төрийн байгууллын ялгааг гэтлэн давах талаар харилцан зохицох, түгшүүртэй байдлыг намжаах тийш ахиц гаргах, бие биеэ гүжирдэн гүтгэх, доромжилж муулахаа зогсоож, санамсаргүй байдлаас зэвсэгт мөргөлдөөн үүсэх аюулаас урьдчилан сэрэмжилж дохио сануулга өгөх, Өмнөд-Умардын Улаан Загалмайн Нийгэмлэгийн бага хурлын үр дүнг үнэлж, Сөүл, Пёняны хооронд утсан харилцааны шууд шугам нээхээр заажээ. Түүнчлэн өндөр түвшинд "Өмнөд-Умардын Зохицуулах Хороог байгуулах зарчмыг мөн оны 10 сард Панмунжомд болсон байна.

1973 оны 6 сард ерөнхийлөгч Пак Жөн Хи “Энх тайван, Нэгдлийн Онцгой Гадаад Бодлогыг” зарлан тунхаглаж үндэсний эв нэгдэл хүртэл Өмнөд, Умардын хооронд энх тайвнаар зэрэгцэн орших, хэрвээ энх тайвнаар нэгтгэх замд тааламжгүй нөлөө үзүүлэхгүй ахул Умард Солонгосыг НҮБ-д элсэхэд эсэргүүцэхгүй гэдгээ нотолсон юм. Пак 1974 оны 1 сард шинэ жилд зориулсан хэвлэлийн бага хурал дээр Өмнөд Умардын хооронд харилцан үл довтолох гэрээ байгуулах, 1978 оны 1 сард “ямарч газар, ямарч үед, ямарч түвшинд” харилцааг сайжруулахад бэлэн байгаагаа удаа дараалан нотолж байв. 1979 оны 6 сард ерөнхийлөгч Пак Жон Хи, АНУ-ын ерөнхийлөгч Жимми Картер нар уулзаж дэлхийн энэ хэсэгт түгшүүрийн гололмтыг намжаах, харилцан ойлголцлыг дэмжих Өмнөд-Умард Солонгос, АНУ-ын албан ёсны төлөөлөгчдийн гурван талын уулзалт хийх саналыг дэвшүүлсэн боловч Пёняны эрх баригчид дээрхи саналыг аанай л эрс эсэргүүцсэн юм. Ер тэрбээр Өмнөд Умардын яриа хэлэлцээг анхлан санаачилж, солонгосыг энх тайван замаар нэгтгэхийн төлөө зүтгэж байсан нэгэн байв.

Өнөөдрийн Өмнөд Солонгосын эдийн засгийн гайхамшгийн эх суурь нь чухамдаа Пак Жөн Хи-г ерөнхийлөгч болсон анхны жилээс эхлэн тавигджээ. Түүний хэрэгжүүлж эхэлсэн экспортын чиглэлтэй эдийн засгийн бодлого, хөгжлийн загвар нь өнөө олон улс оронд үлгэр дууриал болж байгаа билээ. Солонгосын түүхэнд анх удаа үндэсний нөөц хүчийг дээд зэргээр үр өгөөжтэй дайчлан зохион байгуулсан нь Пакуг засгийн эрх барьж байх үед гэж судлаачид үздэг. 1962 онд нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 87-хон ам доллар байсан нь 1980 онд 1503 ам.доллар болж, 1962 онд жилд 56,7 сая долларын бараа, бүтээгдэхүүн экспортолж байсан бол 1980 онд 17,5 тэрбум долларт хүрч энэ хугацаанд эдийн засгийн дундаж өсөлт 9,2 хувь болж байв.

Өмнөд Солонгосын түргэн хөгжлийн гол нууц нь улсын эдийн засгийн удирдлагын тогтолцоотой холбоотой гэж үздэг. Нөхцөл байдалд үнэн зөв дүн шинжилгээ хийж, оновчтой томъёолсон, үр ашигтай эдийн засгийн төлөвлөлт нь 1962 оноос эхэлсэн Анхдугаар Ү жилийн төлөвлөгөө юм. 50-иад оны дундаас хэд хэдэн хувилбартай эдийн засгийн гурав, таван жилийн төлөвлөгөөг АНУ-ын оролцоотойгоор боловсруулсан боловч улс төрийн байдлаас болж хэрэгжээгүй юм. Пак засгийн эрхэнд гарсны дараа өөрийн шууд санаачлагаар 1961 оны 6 сард Эдийн Засгийн Төлөвлөлтийн Хороог байгуулжээ. Хорооны зорилго нь улс орныг Ү, таван жилийн төлөвлөгөөгөөр удирдахад оршиж байв. Тэрээр засгийн газрын эдийн засгийн гол үүргийг тодорхойлохдоо эдийн засаг, хууль эрхийн хоорондын нягт тогтолцоог буй болгох, тухайлбал, Үндсэн хуулийн хүрээнд биенесийн үйл ажиллагааг зохицуулах, эдийн засагт оролцох төрийн үүргийг томъёолох, эдийн засгийн гол, гол хуулиудыг даруй боловсруулж

гаргах, макро эдийн засгийн тогтворжуулалтыг баталгаажуулах, эдийн засгийн микро төвшинд үйлдвэрлэл, худалдаа, ХАА, нийгмийн дэд бүтцийн салбарын үр ашгийг дээшлүүлэх, шударга ёсыг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэж байв. Хувийн хэвшлийнхэнтэй хамтарч Ү жилийн төлөвлөгөөг боловсруулж байсан нь онцлог юм. Төлөвлөгөөний дагуу салбаруудын хөгжлийг засаг захиргааны аргаар бус, харин зах зээлийн механизмыг дэмжин тэргүүлэх болон стратегийн ач холбогдолтой салбарыг эдийн засгийн аргаар урамшуулахыг гол болгож байв. Таван жилийн төлөвлөгөө нь сайн боловсорсон шаардах чиглүүлэн зохицуулах талын аль алиныг багтаасан цогц баримтлал бөгөөд улс орны хөгжлийн тухайн шатанд тохируулан эхний үед зааварлах шаардах тал нь зонхилж байсан бол сүүлийн таван жилийн төлөвлөгөөнүүдэд хувийн секторт өргөн эрх олгосон, хялбархан өөрчилж болох уян шинжтэй байв. Зөвхөн IV таван жилийн төлөвлөгөө эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд тэргүүлэх салбарыг дэмжин хөгжүүлж, уг салбарт төрөл бүрийн хөнгөлөлт олгож иржээ. Анхдугаар таван жилд (1962-1966) ХАА-д хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх, өөрийгөө хангах, эдийн засгийн үндсийг тавих, II таван жилд (1966-1971) өөрийгөө хангах салбарын хөгжлийг түргэтгэх, аж үйлдвэрт экспортын чиглэлтэй бүтцийн өөрчлөлт хийх, III таван жилд (1972-1976) эдийн засгийн хувьд бие даах, орон нутгийн хөгжилд түлхэц өгөх, хүнд болон химийн үйлдвэрийг хөгжүүлэх, IV таван жилд (1977-1981) эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, удирдлагыг боловсронгуй болгох, судалгааны ажлыг дэмжиж, оюуны хөдөлмөр шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр зааж хэрэгжүүлжээ.

Пакийн засаг захиргаа улс орныг авч явах үндэсний пүүсүүдийг хөл дээр нь зогсоход нь ихээхэн дэмжлэг үзүүлэх бодлого баримталсны үрээр Өмнөд Солонгосын томоохон пүүс, компаниуд дэлхийн түвшинд хүртэл бэхжсэн юм. Эдийн засагт зах зээлийн механизмын үйлчлэлийг хүчтэй болгож, өрсөлдөөнийг хадгалах зорилгоор жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд Пак Жөн Хи онцгой анхаарал тавьж байлаа. 1962 онд түүний ивээл санаачилгаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих Жижиг Бизнесийн Солонгосын Холбоо, Худалдааг Дэмжих Солонгосын Корпораци КОТРА зэрэг засгийн газрын болон засгийн газрын бус байгууллагууд байгуулагджээ. Өмнөд Солонгосын эдийн засгийн тулгын чулуу болсон Ульсанын үйлдвэрлэлийн цогцолбор, Поханы дэлхийд алдартай төмөр, болдын үйлдвэр, Сөүлийн дүүрэг дэх Кюрогийн экспортын үйлдвэрлэлийн цогцолбор, Шинэ Тосгоны Хөдөлгөөн, анхны атомын цахилгаан станц зэрэг нь 60-аад он, 70 оны эхээр шаваа тавьж гараагаа эхэлсэн билээ. Эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл, санаа ерөнхийлөгчийн анхаарлыг ихэд татаж байсан бөгөөд 1970 оноос тус улсад экспортын чиглэлтэй боловсруулах үйлдвэр бүхий чөлөөт бүс хоёрыг бий болгосон нь эдийн засгийн гадаад харилцааг эрчимжүүлэх чухал хөшүүрэг болжээ. Пакийн Засгийн газар эхний үед гадаадын шууд хөрөнгө оруулалтаас

тодорхой хэмжээнд зайлсхийж, харин хөнгөлөлттэй болон ердийн зээл, буцалтгүй тусламж авах чиглэлийг баримталж байсан нь зөв стратеги байсан гэж судлаачид үздэг. Энэ нь хойд хөрштэйгээ дайны байдалтай байсан хийгээд мөн ч үндэсний онцлог байдлыг харгалзсан хэрэг байлаа. 70 оны эхнээс үе шаттайгаар гадаадын хөрөнгө оруулалтанд тааламжтай нөхцөлийг бүрдүүлж иржээ.

Өмнөд Солонгост эдийн засгийн бодлогын шийдвэр гаргах үйл явц нь Японсоос зарчмын ялгаатай байсан бөгөөд хэрэв тэнд хүчтэй улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн намуудын үүрэг шийдвэрлэх ач холбогдолтой байсан бол Өмнөд Солонгост ерөнхийлөгч болон эдийн засгийн яамдын сайд нар, засгийн газрын хариуцлагатай ажилтнуудын үүрэг чухал ач холбогдолтой байсан юм. Түүнчлэн армийн чөлөөнд гарсан генерал, хурандаа нарын үүрэг роль ч мэдэгдэхүйц нөлөөтэй байв. Харин 80-аад оны дундаас улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн намуудын нөлөө нэмэгдэж ирсэн байна.

1974 оны 8 сард Сөүлийн Үндэсний Театрт ерөнхийлөгч Пак Жөн Хи-г үг хэлж байхад нь түүний амь насанд халдаж, Пак өөрөө амьд үлдэж харин түүний гэр бүл Юук Ён Су харамсалтайгаар алагджээ. Тэрбээр "Юшин" Үндсэн Хуулийн ёсоор Үндэсний Нэгдлийн Хурлаас ерөнхийлөгчөөр сонгогдоод зургаа илүү жилийн нүүр үзээд байсан юм. 70-аад оны сүүлээр улс төрийн өшөө хорсол авах, сөрөг хүчний даралт шахалт, оюутны жагсаал, цуглаан нь түүнд хүчтэй дарамт болж байлаа. 1979 оны 3 сард Пакын гандан бууршгүй өрсөлдөгч Ким Дэ Жун, ерөнхийлөгч агсан Юунь По-Сон, шашны тэрс үзэлтний тэргүүн Нам Сок Хон нар баривчлагдсан нь улс төрийн тогтворгүй байдлыг улам нэмэгдүүлсэн юм. 1979 оны 10-р сарын 26-ны оройн зоог дээр Пак Жөн Хи-өөрийн ТТГ-ын удирдагч Ким Чэй Кюгийн гарт алагджээ. Сүүлийн үеийн мэдээгээр бол энэхүү хуйвалдааныг зохион байгуулагч нь түүний дараагаар ерөнхийлөгч болсон генерал Чон Ду Хван, Ро Дэ У нар гэж үзэж байна.

Өнөөдөр ерөнхийлөгч Пан Жөн Хи-гийн БНСУ-ын түүхэнд гүйцэтгэсэн зүтгэлийг Өмнөд Солонгосчууд гүнээ хүндэтгэн үздэг ажээ.